ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДУА-2025/03/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дундговь аймаг

2025 он


Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ
Утас: 70592225
Цахим хаяг: Oyun-Erdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан
Утас: 70593113
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Б.Мягмарсүрэн
Утас: 70593113
Цахим хаяг: Myagmarsurenby@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 8

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин** ........ 8

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ........ 8

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд** ........ 8

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 8

**4.1 Ерөнхий зүйл** ........ 8

**4.2 Материаллаг байдал** ........ 8

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 8

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 8

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 8

**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 8

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 8

5. Аудитын илрүүлэлт ........ 8

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........ 10

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншанд сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208. Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.03.25 № 87

танай ________ -ны № ________ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛСУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ДОРЖСҮМБЭР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар баяр наадмын зардлыг санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс 15.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, санхүүгийн тайлан дахь 0.5 сая төгрөгийн өглөг, 23.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
2. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлан дахь 39.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 2.4 дахин их, зардлыг жишиг хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан, санхүүгийн тайлан дахь өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой

4825020298

зүйлийн талаар тодруулахад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.7 дахин өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлснээр 1 төсвийн байгууллагын 1 албан хаагч 9.1 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоолын дагуу сумдын Эмийн эргэлтийн санг татан буулгах шийдвэр гарч, тус сумын Эмийн эргэлтийн сангийн 16.1 сая төгрөгийн хөрөнгө, бараа материал, 19.3 сая төгрөгийн авлага, 20.0 сая төгрөгийн өр төлбөрийг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэн бүртгэсэн байна.

Уг үйл явцуудыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар нь засаг даргын нөөц сангаас 41.9 сая төгрөгийн өвсний худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгож, босго үнийг мөрдөлгүй шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-д /Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно/, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтад /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ./, хавсралтын 2–т /Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар нь бараа, ажлын хувьд 20.0 сая/ тус тус заасныг зөрчсөн тул гол асуудал гэж үзэн албан шаардлага хүргүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилт, 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 78 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 73.5 хувьтай үнэлэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үзнэ.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/Мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 747,315.7 | 1,252,560.1 |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 516,709.4 | 940,858.5 |
| 33 | **АВЛАГА** | 146,298.1 | 152,313.0 |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | | 2,220.0 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 84,308.1 | 157,168.6 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 1,609,157.4 | 2,093,748.5 |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,609,157.4 | 2,093,748.5 |
| 39200 | **Биет хөрөнгө** | 1,580,965.8 | 2,066,336.5 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 28,191.6 | 27,412.0 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 2,356,473.1 | 3,346,308.6 |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 25,431.9 | 77,211.5 |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 25,431.9 | 77,211.5 |
| 41300 | **Өглөг** | 25,431.9 | 77,211.5 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 2,331,041.2 | 3,269,097.1 |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,331,041.2 | 3,269,097.1 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 465,524.7 | 465,524.7 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | 1,614,085.7 | 2,552,141.6 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 251,430.8 | 251,430.8 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 2,356,473.1 | 3,346,308.6 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,556,213.8 | 2,743,554.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 314,136.5 | 683,861.2 |
| 110 | Орлогын албан татвар | 183,591.2 | 530,991.5 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 183,591.2 | 530,991.5 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 82,089.6 | 80,997.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 48,455.7 | 71,872.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 488,513.4 | 1,101,199.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 488,193.4 | 1,101,199.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 753,563.9 | 958,493.8 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 933,619.0 | 1,420,859.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 933,619.0 | 1,420,859.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 873,553.8 | 1,373,395.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 282,750.7 | 490,578.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,882.6 | 57,972.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 31,096.2 | 327,564.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 49,060.1 | 50,886.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,035.0 | 55,220.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 19,668.0 | 31,380.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 261,171.6 | 12,265.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 178,889.6 | 347,527.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 60,065.2 | 47,464.3 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 622,594.8 | 1,322,695.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 284,196.1 | 384,639.0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 338,398.7 | 938,056.0 |

**12,866.4 мг 8,623.8**

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөг/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,956,802.2 | 1,956,802.2 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -56.7 | -56.7 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,956,745.5 | 1,956,745.5 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 35,896.9 | 35,896.9 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 338,398.7 | 338,398.7 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,331,041.2 | 2,331,041.2 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,331,041.2 | 2,331,041.2 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,331,041.2 | 2,331,041.2 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 938,056.0 | 938,056.0 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 3,269,097.1 | 3,269,097.1 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 1,142,683.9 | 1,969,081.3 |

| | | | |
|---|---|---|---|
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **314,136.5** | **683,861.2** |
| **110** | **Орлогын албан татвар** | 183,591.2 | 530,991.5 |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | 183,591.2 | 530,991.5 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | 82,089.6 | 80,997.8 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | 48,455.7 | 71,872.0 |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | 3,828.6 | 9,512.1 |
| **1181** | **Газрын төлбөр** | 44,627.1 | 62,359.9 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **103,950.1** | **326,726.2** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 103,630.1 | 326,726.2 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **724,597.3** | **958,493.8** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **793,215.4** | **1,265,876.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **793,215.4** | **1,265,876.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **762,116.8** | **1,218,411.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 283,113.8 | 490,022.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 34,454.6 | 57,972.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,464.3 | 328,394.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 35,038.2 | 52,200.4 |
| **2105** | **Норматив зардал** | 308.0 | 1,080.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,924.4 | 61,663.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 19,668.0 | 31,380.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 261,471.1 | 13,265.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 79,674.5 | 182,432.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,098.6 | 47,464.3 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 349,468.5 | 703,205.3 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | 315,382.0 | 279,056.2 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 315,382.0 | 279,056.2 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 315,382.0 | 279,056.2 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | (315,382.0) | (279,056.2) |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | (40,000.0) | - |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | (5,913.5) | 424,149.1 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 522,622.9 | 516,709.4 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 516,709.4 | 940,858.5 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,142,736.3** | **1,485,155.2** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,408,240.0** | **1,209,898.4** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,371,485.0** | **1,175,908.4** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 540,776.5 | 490,022.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 68,567.5 | 57,972.2 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 328,620.6 | 327,221.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 40,178.3 | 38,608.0 |
| 2105 | Норматив зардал | 1,100.0 | 1,080.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 61,894.9 | 60,810.9 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 31,613.4 | 31,380.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,947.7 | 4,382.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 290,786.1 | 164,430.8 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **36,755.0** | **33,990.0** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,755.0 | 33,990.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **530,680.2** | **275,256.7** |
| 23 | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **203,816.1** | **-** |
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,142,736.3** | **1,677,263.4** |
| 31 | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **329,096.6** | **315,932.6** |
| 32 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,409,024.2** | **1,293,357.4** |
| 35 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **404,615.5** | **67,973.4** |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 315,298.5 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 496,316.5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **52,027.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **52,027.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **38,552.8** |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,172.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,592.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,452.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,883.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,451.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **13,474.3** |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | **13,474.3** |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **52,027.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **52,027.0** |

## 3. Аудитын илрүүлэлт

*3.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Аудитаар нийт 31,667.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 661.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 31,006.0 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт 661.8 мянган төгрөгийн 1 алдаа[1] илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Мал хамгаалах сангийн хувь хүнээс авах 661.8 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлагыг дутуу тайлагнасан;

*Залруулаагүй алдаа:*

Аудитаар нийт 31,006.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлсэн.

***3.1.1 Албан шаардлага***

- ➢ Байгаль хамгаалах сангийн 10,950.0 мянган төгрөгийн санхүүгийн тайлан дахь өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*/, мөн хуулийн 20.2.6-д /*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/ /заасныг;
- ➢ Аудитаар 20,056.0 мянган төгрөгийн татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн оруулаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т /*Бүх шатны төсвийн*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ*/, 41.2.1-т /*Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*/, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19-д /*нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах*/ заасныг тус тус зөрчсөн байна.

*3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал*

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:*

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Засаг даргын Тамгын газар | 1 | 1 | | | | 1 | | |
| 2 | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 1 | | 1 | | | | | |
| 3 | Мал хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 1 | | 1 | | | | | |
| 5 | Орон нутгийн хөгжлийн | 1 | | 1 | | | | | |
| 6 | Байгаль хамгаалах сан | 1 | | 1 | | | | | |
| | **НИЙТ** | 6 | 1 | **5** | | | **1** | | |

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт дүнгээр 157,936.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3,678.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 154,258.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлагыг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 97.7 хувийг залруулагдаагүй, 2.3 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

| Байгууллгын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | 16.2 | 1 | 16.2 | | | 1 | 16.2 | | | | |
| Засаг даргын Тамгын газар | 1 | 3,000.0 | 1 | 3,000.0 | | | 1 | 3,000.0 | | | | |
| Мал хамгаалах сан | 1 | 661.8 | 1 | 661.8 | | | 1 | 661.8 | | | | |
| Дүн | **3** | **3,678.0** | **3** | **3,678.0** | | | **3** | **3,678.0** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

| Байгууллгын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЗДТГ | 5 | 40,576.3 | | | 5 | 40,576.3 | | | 1 | 0.0 | | |
| ИТХ | 1 | 1,800.0 | | | 1 | 1,800.0 | | | | | | |
| БХС | 1 | 10,950.0 | | | 1 | 10,950.0 | | | | | | |
| ОНХС | 1 | 38,968.9 | | | 1 | 38,968.9 | | | | | | |
| **Нийт дүн** | **8** | **92,295.2** | **-** | **-** | **8** | **92,295.2** | **-** | **-** | **1** | **0.0-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:**

| Байгууллгын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| ЗДТГ | 1 | 41,906.9 | | | 1 | 41,906.9 | | | | | | |
| ОННТ | 1 | 20,056.0 | | | 1 | 20,056.0 | | | | | | |
| **Нийт дүн** | **2** | **61,962.9** | **0** | **0.0** | **2** | **61,962.9** | 0 | - | | | | |